



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2023 оны 07 сарын 20 өдөр

Дугаар 380

Улаанбаатар хот

Удирдамж болгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6, 21 дүгээр зүйлийн 6 дахь, Хөдөлмөрийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Хархорин АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг удирдамж болгосугай.

1.1. Компанийн Нэр дэвшүүлэх хорооноос ирүүлсэн дүгнэлтийг харгалзан Чүлтэмийн Алтанбаганыг “Хархорин АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн Гүйцэтгэх захирлаар холбогдох хууль тогтоомжийн дагуу томилж, Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах.

2. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Н.ГАНБОЛД